



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/080/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2026 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Болормаа
Утас: 70357955 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.25 № 78
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХОТ
ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН ДАРГА
Б.БААСАНСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үүнд:

1. Тайлант онд ээлжийн амралттай 5 ажилтанд 1,659.8 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон,
2. Сахилгын шийтгэлтэй 7 ажилтанд 2,557.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон,
3. Тайлант онд 4 ажилтанд 1,396.6 мянган төгрөгийн илүү цалинг олгосон,
4. Байгууллагын дарга өөрөө өөртөө илүү цагийн хөлс, үр дүнгийн урамшуулалд нийт 2,315.2 мянган төгрөг авсан,
5. Тушаал шийдвэргүй захиргааны 5 ажилтанд 1,209.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон,
6. Хүний нөөцийн албаны даргын дансаар дамжуулан анхан шатны нотлох баримтгүй 3,990.0 мянган төгрөгийг зарцуулсан,

612505439

7. Тайлант онд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг харьцуулалтын аргаар худалдан авах байтал 70,191.2 мянган төгрөгөөр шууд худалдан авсан,
8. Тайлант оны 12 дугаар сард 458,400.5 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг худалдан авч их хэмжээгээр нөөцөлсөн,
9. Тайлант оны 12 дугаар сарын 25-ны өдөр тээврийн хэрэгслийн дугуйг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар авах байтал 109,660.0 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн,
10. Ажил олгогчийн шийдвэргүй өөрийн санаачилгаар илүү цагаар ажилласан захиргааны ажилчдад "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-гүй 9,231.2 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон,
11. Захиргааны 15 ажилтныг 12,775.9 мянган төгрөгийн өвөл зуны нормын хувцсаар хангасан.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд аудитын иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 18/06 дугаар тогтоолоор Орхон аймгийн Хот тохижуулах газрын орон тоог 332 байхаар тогтоосноос хойш өөрчлөлт ороогүй нь Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-д "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж тусгасныг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Хот тохижуулах газрын дарга нь аймгийн засаг даргатай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж, 2024 оны гэрээний биелэлтийг 92%-иар дүгнүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 17 дугаар тогтоолоор хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 1,736,500.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,147,929.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ. Нийтийн тээврийн үйлчилгээний орлого 158,143.7 мянган төгрөгийг Эрдэнэт санд төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,060,624,287.50	2,451,326,123.50
33	АВЛАГА	00.00	36,661,116.00
335	Бусад авлага	00.00	36,661,116.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	36,661,116.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,060,624,287.50	2,414,665,007.50
351	Түүхий эд материал	689,826,811.50	1,877,131,649.50
35110	Тусгай зориулалттай материал	689,826,811.50	1,877,131,649.50
354	Хангамжийн материал	370,797,476.00	537,533,358.00
35410	Бичиг хэргийн материал	1,257,850.00	325,900.00
35420	Аж ахуйн материал	166,588,632.00	226,837,760.00
35430	Сэлбэг хэрэгсэл	113,396,400.00	239,785,200.00
35450	Барилгын засварын материал	71,933,096.00	54,863,000.00
35460	Хүнсний материал	3,100,000.00	1,200,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,521,498.00	14,521,498.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	65,678,461,329.28	99,277,287,092.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	65,678,461,329.28	99,277,287,092.23
392	Биет хөрөнгө	65,172,261,329.28	83,415,179,092.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,246,390,606.29	1,234,524,873.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-502,597,703.10	-468,073,952.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,549,613,400.60	12,406,464,385.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,005,868,321.59	-4,604,930,748.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	385,372,825.00	405,833,412.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-92,594,813.36	-132,966,567.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,895,966.00	67,018,462.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-111,805,491.60	-62,616,438.07
39209	Зам, гүүрийн байгууламж	60,600,175,891.56	78,367,562,539.99
39210	Хуримтлагдсан элэгдэл	-28,523,972,205.37	-36,603,810,826.73
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,992,618,445.07	47,268,923,872.04
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,480,967,270.22	-14,462,749,919.16
393	Биет бус хөрөнгө	506,200,000.00	15,862,108,000.00
39301	Програм хангамж	1,397,000.00	1,397,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,397,000.00	-1,397,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	506,200,000.00	15,862,108,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	66,739,085,616.78	101,728,613,215.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,472,686.99	15,976,763.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,472,686.99	15,976,763.00
413	Өглөг	36,472,686.99	15,976,763.00
4136	Бусад өглөг	36,472,686.99	15,976,763.00
41361	Байгууллагад төлөх өглөг	36,472,686.99	15,286,763.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	690,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	66,702,612,929.79	101,712,636,452.73
51	Засгийн газрын хувь оролцоо	66,702,612,929.79	101,712,636,452.73

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,235,927,847.02	7,235,927,847.02
51101	Өмч: - төрийн	7,235,927,847.02	7,235,927,847.02
512	Хуримтлагдсан үр дүн	54,081,036,365.16	89,091,059,888.10
51210	Өмнөх үеийн үр дүн	54,081,036,365.16	54,081,036,365.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	35,010,023,522.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,385,648,717.61	5,385,648,717.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	66,739,085,616.78	101,728,613,215.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	39,012,705,599.45	68,182,169,768.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,063,390,319.45	49,173,285,743.32
120	Нийтлэг татварын бус орлого	25,063,390,319.45	49,173,285,743.32
120009	Бусад орлого		15,924,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/		47,509,727,307.32
120012	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/	-	1,647,634,436.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,949,315,280.00	19,008,884,025.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,260,945,280.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,200,745,280.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,500,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	700,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,688,370,000.00	14,971,335,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,688,370,000.00	14,971,335,400.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	4,037,548,625.02
1330	Төсвийн захирагчдаас	-	4,037,548,625.02
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	22,282,966,596.60	33,169,021,245.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,282,966,596.60	33,169,021,245.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,999,236,664.35	30,742,085,202.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,155,676,749.51	7,888,044,294.46
210101	Үндсэн цалин	3,517,423,290.60	4,092,419,604.44
210102	Нэмэгдэл	1,885,121,070.03	2,780,477,268.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	380,652,086.45	586,420,376.79
210104	Урамшуулал	372,480,302.43	428,727,045.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	792,246,803.07	1,057,439,150.69
210201	Тэтгэврийн даатгал	409,245,303.07	593,540,350.69
210202	Тэтгэмжийн даатгал	63,834,400.00	92,810,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	159,586,000.00	139,061,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	31,917,200.00	46,405,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	127,663,900.00	185,621,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,236,272.64	97,735,467.88
210301	Гэрэл, цахилгаан	10,613,510.26	17,800,386.50
210302	Түлш, халаалт	44,309,848.85	29,020,132.29

210303	Цэвэр, бохир ус	19,612,913.53	11,314,949.09
210304	Байрны түрээс	700,000.00	39,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,378,559,455.00	2,994,834,749.00
210401	Бичиг хэрэг	9,870,100.00	13,588,840.00
210402	Тээвэр, шатахуун	2,325,051,626.00	2,901,234,288.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,260,507.00	6,153,481.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,284,650.00	33,660,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,092,572.00	40,197,520.00
2105	Нормативт зардал	164,219,928.00	241,023,862.00
210502	Хоол, хүнс	92,140,625.00	90,132,130.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	72,079,303.00	150,891,732.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	432,170,592.18	502,244,334.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,627,150.00	36,699,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	157,398,562.18	213,378,334.00
210604	Урсгал засвар	224,144,880.00	252,166,900.00
2107	Томилолт, зочны зардал	315,000.00	400,000.00
210702	Дотоод албан томилолт	315,000.00	400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,649,360,361.39	4,068,510,799.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,529,892,070.89	3,937,414,294.34
210803	Даатгалын үйлчилгээ	37,408,401.00	29,864,521.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,318,320.50	90,246,826.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,496,000.00	2,156,000.00
210807	Газрын төлбөр	75,245,569.00	8,829,158.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,351,451,502.56	13,891,852,544.43
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,016,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,347,435,502.56	13,891,852,544.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,283,729,932.25	2,426,936,043.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,003,289.00	103,328,580.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	76,414,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,391,569.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,611,720.00	26,914,480.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	120,784,362.00	624,998,344.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,784,362.00	624,998,344.69
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,026,942,281.25	1,698,609,118.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,026,942,281.25	1,698,609,118.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	16,729,739,002.85	35,013,148,522.88
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,124,999.94
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	3,124,999.94
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(3,124,999.94)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	16,729,739,002.85	35,010,023,522.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	13,949,315,280.00	19,024,808,025.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,949,315,280.00	19,008,884,025.02
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,260,945,280.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,688,370,000.00	19,008,884,025.02
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,688,370,000.00	14,971,335,400.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	4,037,548,625.02
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	13,949,315,280.00	19,024,808,025.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,949,315,280.00	19,024,808,025.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,665,485,347.75	16,597,871,981.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,068,714,718.73	7,889,153,080.46
210101	Үндсэн цалин	3,430,479,031.82	4,093,528,390.44
210102	Нэмэгдэл	1,885,103,298.03	2,780,477,268.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	380,652,086.45	586,420,376.79
210104	Урамшуулал	372,480,302.43	428,727,045.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	792,246,803.07	1,057,439,150.69
210201	Тэтгэврийн даатгал	409,245,303.07	593,540,350.69
210202	Тэтгэмжийн даатгал	63,834,400.00	92,810,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	159,586,000.00	139,061,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	31,917,200.00	46,405,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	127,663,900.00	185,621,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,687,950.36	97,735,467.88
210301	Гэрэл, цахилгаан	14,065,187.98	17,800,386.50
210302	Түлш, халаалт	44,309,848.85	29,020,132.29
210303	Цэвэр, бохир ус	19,612,913.53	11,314,949.09
210304	Байрны түрээс	700,000.00	39,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,229,561,302.00	2,889,558,821.00
210401	Бичиг хэрэг	10,044,500.00	11,752,690.00
210402	Тээвэр, шатахуун	2,168,733,185.00	2,820,897,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,260,507.00	6,144,681.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,900,000.00	34,280,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,623,110.00	16,483,450.00
2105	Нормативт зардал	172,877,200.00	215,089,750.00
210502	Хоол, хүнс	96,374,200.00	70,191,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	76,503,000.00	144,898,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	547,131,800.00	682,779,406.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	66,125,100.00	71,926,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	209,648,300.00	240,371,556.00
210604	Урсгал засвар	271,358,400.00	370,481,850.00
2107	Томиллолт, зочны зардал	315,000.00	400,000.00
210702	Дотоод албан томиллолт	315,000.00	400,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,771,934,573.59	3,703,289,805.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,659,903,552.09	3,578,061,533.33
210803	Даатгалын үйлчилгээ	37,408,401.00	29,864,521.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,318,320.50	6,264,751.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,496,000.00	2,387,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,000,000.00
210807	Газрын төлбөр	67,808,300.00	83,712,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,016,000.00	62,426,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	59,760,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,016,000.00	2,666,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,283,829,932.25	2,426,936,043.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,103,289.00	103,328,580.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	76,414,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,391,569.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,711,720.00	26,914,480.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	120,784,362.00	624,998,344.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,784,362.00	624,998,344.69
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,026,942,281.25	1,698,609,118.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,026,942,281.25	1,698,609,118.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	37,351,297,362.31	49,972,873,926.94
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	37,351,297,362.31	49,972,873,926.94
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	16,729,739,002.85	16,729,739,002.85
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	54,081,036,365.16	66,702,612,929.79
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	54,081,036,365.16	66,702,612,929.79
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	54,081,036,365.16	66,702,612,929.79
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	35,010,023,522.94	35,010,023,522.94
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,235,927,847.02	5,385,648,717.61	89,091,059,888.10	101,712,636,452.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,062,016,000	13,272,776,728
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,062,016,000	13,272,776,728
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,956,801,900	13,169,448,148
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,281,076,800	7,889,153,080
210101	Үндсэн цалин	4,314,000,700	4,093,528,390
210102	Нэмэгдэл	2,899,230,200	2,780,477,268
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,138,777,100	586,420,377
210104	Урамшуулал	929,068,800	428,727,045
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,252,790,300	1,057,439,151
210201	Тэтгэврийн даатгал	788,891,500	593,540,351
210202	Тэтгэмжийн даатгал	92,810,800	92,810,800
210203	ҮОМШӨ-ний даатгал	139,061,100	139,061,100
210204	Ажилгүйдлийн даатгал	46,405,400	46,405,400
210205	Эрүүл мэндийн даатгал	185,621,500	185,621,500
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,537,100	58,135,468
210301	Гэрэл, цахилгаан	21,822,400	17,800,387
210302	Түлш, халаалт	68,805,600	29,020,132
210303	Цэвэр, бохир ус	27,909,100	11,314,949
2104	Хангамж, бараа материалын зардал	2,863,401,700	2,862,856,660
210401	Бичиг хэрэг	7,000,000	6,770,640
210402	Тээвэр, шатахуун	2,804,394,000	2,804,394,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,283,700	4,228,370

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,400,000	34,280,500
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,324,000	13,183,150
2105	Нормативт зардал	239,333,200	215,089,750
210502	Хоол, хүнс	70,193,200	70,191,230
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	169,140,000	144,898,520
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	531,841,300	516,605,706
210601	Багаж, техник, хэрэгсэл	69,152,800	68,746,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	255,101,900	240,371,556
210604	Урсгал засвар	207,586,600	207,488,150
2107	Томилолт, зочны зардал	2,500,000	400,000
210702	Дотоод албан томилолт	2,500,000	400,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	603,061,500	507,341,833
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	455,430,600	382,113,560
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	29,904,900	29,864,521
210804	Тээврийн хэрэгслийн татвар	9,754,000	6,264,752
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	6,110,000	2,387,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,150,000	3,000,000
210807	Газрын төлбөр	83,712,000	83,712,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,260,000	62,426,500
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,760,000	59,760,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000	2,666,500
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,214,100	103,328,580
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	76,414,100	76,414,100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,800,000	26,914,480
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,062,016,000	14,971,335,400
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,062,016,000	14,971,335,400
132001	Орон нутгийн төсвөөс	15,062,016,000	14,971,335,400

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 30.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 30.0 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

Харилцах дансаар 2,815,402.4 мянган төгрөгийн шатахууны үнэ шилжүүлсэн боловч шатахууны үнийн хөнгөлөлтөөс 30,092 төгрөгийн шатахуун бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", УСНББОУС 1 болон толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул санхүүгийн тайлангийн аудитаар залруулав.

Аудитаар нийт 673,387.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 13,128.5 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 660,258.8 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант онд ээлжийн амралттай 5 ажилтанд 1,659.8 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон, сахилгын шийтгэлтэй 7 ажилтанд 2,557.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, тушаал шийдвэргүй 4 ажилтанд 1,396.6 мянган төгрөгийн цалинг илүү олгож суутгаагүй, байгууллагын дарга өөрөө өөртөө илүү цагийн хөлс, үр дүнгийн урамшуулалд нийт 2,315.2 мянган төгрөг авсан, тушаал шийдвэргүй захиргааны 5 ажилтанд 1,209.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон, хүний нөөцийн албаны даргын дансаар дамжуулан анхан шатны нотлох баримтгүй 3,990.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчилд 6 төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Тайлант онд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг харьцуулалтын аргаар худалдан авах байтал 70,191.2 мянган төгрөгөөр шууд худалдан авсан, 12 дугаар сард 458,400.5 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг худалдан авч их хэмжээгээр нөөцөлсөн, тайлант оны 12 дугаар сарын 25-ны өдөр тээврийн хэрэгслийн дугуйг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар авах байтал 109,660.0 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн, ажил олгогчийн шийдвэргүй өөрийн санаачилгаар илүү цагаар ажилласан захиргааны ажилчдад "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-гүй 9,231.2 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон, захиргааны 15 ажилтныг 12,775.9 мянган төгрөгийн өвөл зуны нормын хувцасаар хангасан зөрчилд 5 албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

1. Тодруулга тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-т "санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025-01-03-ны өдрийн А/3 тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх зааврыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж байх.

Дээрх зөрчлийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөг/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Харилцах дансаар 2,815,402.4 мянган төгрөгийн шатахууны үнэ шилжүүлсэн боловч шатахууны үнийн хөнгөлөлтөөс 30,092 төгрөгийн шатахуун бүртгээгүй	1	30.0	1	30.0			1	30.0				
Дүн	1	30.0	1	30.0			1	30.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөг/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд ээлжийн амралттай 5 ажилтанд 1,659.7 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон.	1	1,659.8	1	1,659.8								
Сахилгын шийтгэлтэй 7 ажилтанд 2,557.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон	1	2,557.5	1	2,557.5								
Тайлант онд 4 ажилтанд 1,396.6 мянган төгрөгийн илүү цалинг олгосон.	1	1,396.6	1	1,396.6								
Байгууллагын дарга өөрөө өөртөө илүү цагийн хөлс, үр дүнгийн урамшуулалд нийт 2,315.2 мянган төгрөг авсан.	1	2,315.2	1	2,315.2								
Тушаал шийдвэргүй захиргааны 5 ажилтанд 1,209.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон.	1	1,209.4	1	1,209.4								
Хүний нөөцийн албаны даргын дансаар дамжуулан анхан шатны нотлох баримтгүй 3,990.0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	3,990.0	1	3,990.0								
Тайлант онд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг харьцуулалтын аргаар худалдан авах байтал 70,191.2 мянган төгрөгөөр шууд худалдан авсан.	1	70,191.2					1	70,191.2				

Тайлант оны 12 дугаар сард 458,400.5 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг худалдан авч их хэмжээгээр нөөцөлсөн.	1	458,400.5			1	458,400.5					
Тайлант оны 12 дугаар сарын 25-ны өдөр тээврийн хэрэгслийн дугуйг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар авах байтал 109,660.0 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн.	1	109,660.0			1	109,660.0					
Ажил олгогчийн шийдвэргүй өөрийн санаачилгаар илүү цагаар ажилласан захиргааны ажилчдад “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-гүй 9,231.2 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон.	1	9,231.2			1	9,231.2					
Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.	1	-					1	-			
Дүн	11	660,611.4	6	13,128.5	4	647,482.9	1	-			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Захиргааны 15 ажилтныг 12,775.9 мянган төгрөгийн өвөл зуны нормын хувцасаар хангасан.	1	12,775.9			1	12,775.9		
Дүн	1	12,775.9			1	12,775.9		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1				1			
2	Төсөл, хөтөлбөр									

3	ЗГС							
4	ТТЗ							
5	ТЕЗ							
НИЙТ		1	1				1	